# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

## 2016 оны 11 дүгээр сар

**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 11 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 4.9%-иар буюу 381.3 сая ам.доллараар буурч 7356.3 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 0.8%-иар буюу 33.8 сая ам.доллараар өссөн хэдий ч импорт 11.9%-иар буюу 415.1 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1197.1 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 448.8 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

**Хүснэгт 1.** Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | Жилээр | | | Өөрчлөлт | | | | Эхний 11 сараар | | | Өөрчлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2014/2013 | | 2015/2014 | | | | | 2015/2014 | | 2016/2015 | |
| | 2013 | 2014 | 2015 | Дүн | Хувь | Дүн | Хувь | 2014 | 2015 | 2016 | Дүн | Хувь | Дүн | Хувь |
| **Эргэлт** | **10,627** | **11,011** | **8,467** | **384** | **3.6%** | **(2,544)** | **-23.1%** | **10,022** | **7,738** | **7,356.3** | **(2,284)** | **-22.8%** | **(381)** | **-4.9%** |
| Экспорт | 4,269 | 5,774 | 4,669 | 1,505 | 35.3% | (1,105) | -19.1% | 5,190 | 4,243 | 4,277 | (947) | -18.2% | 33.8 | 0.8% |
| Импорт | 6,358 | 5,237 | 3,797 | (1,121) | -17.6% | (1,440) | -27.5% | 4,832 | 3,495 | 3,080 | (1,338) | -27.7% | (415.1) | -11.9% |
| **Тэнцэл** | **(2,089)** | **538** | **872** | **2,626** | | **335** | **62.2%** | **358** | **748** | **1,197.1** | **391** | | **449** | **60.0%** |

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь хүчин зүйлүүдийн нэг юм. Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2016 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 1265.8 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 224.4 сая ам.доллараар өссөн байна.

**Зураг 1.** Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




**Зураг 2.** Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар




**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 60.0% буюу 4415.4 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.3% буюу 834.6 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 8.6%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 16.8%-иар тус тус буурсан байна.

**Зураг 3.** Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/




**Хүснэгт 2.** Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

| Үнийн индексийн төрөл* | 2015.11 сар | 2016.10 сар | 2016.11 сар | Жил Δ | Сар Δ |
|---|---|---|---|---|---|
| **Экспорт** | **0.76** | **0.73** | **0.78** | **4%** | **8%** |
| Зэсийн баяжмал | 0.39 | 0.32 | 0.31 | -20% | -1.0% |
| Чулуун нүүрс | 0.41 | 0.44 | 0.51 | 23% | 15.4% |
| Ямааны угаасан ноолуур | 0.34 | 0.31 | 0.33 | -3% | 6.1% |
| **Импорт** | **0.61** | **0.57** | **0.52** | **-15%** | **-9%** |
| Хэрэглээний бараа | 0.81 | 0.73 | 0.74 | -9% | 1% |
| Хөрөнгө оруулалтын бараа | 0.56 | 0.52 | 0.38 | -32% | -26% |
| Нефтийн бүтээгдэхүүн | 0.51 | 0.49 | 0.49 | -4% | 0% |
| **Худалдааны нөхцөл** | **1.23** | **1.28** | **1.51** | **23%** | **18%** |

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 22.7%-иар, өмнөх сараас 17.9%-иар өсч 1.513-д хүрлээ. Тайлант сард хөрөнгө оруулалтын төрлийн импортын үнэ буурсан, нүүрсний экспортын үнэ өссөнөөс худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирсан байна.

** Энэхүү тоймыг ГТЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.*

Экспорт 2016 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 0.8%-иар буюу 33.8 сая ам.доллараар өссөн. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 2.4 нэгж хувиар өсөхөд нөлөөлсөн бол уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нийт экспортыг 1.1 нэгж хувиар буурахад нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 1.8 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 2.3 нэгж хувиар өссөн байна.

**Хүснэгт 3.** Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2014 | | | 2015 | | | 2016 | | | Δ (2015/2014) | | | Δ (2016/2015) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **1. Уул уурхай** | | **4,648** | **90%** | | **3,714** | **88%** | | **3,666** | **86%** | **(935)** | **-20%** | **-18%** | **(48)** | **-1%** | **-1.1%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 1,253 | 2,288 | 44% | 1,335 | 2,072 | 49% | 1,440 | 1,497 | 35% | (216) | -9% | -4% | (575) | -28% | -14% |
| 1.2. Чулуун нүүрс | 16,909 | 760 | 15% | 12,831 | 508 | 12% | 22,019 | 772 | 18% | (251) | -33% | -5% | 264 | 52% | 6% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | 6,330 | 602 | 12% | 7,386 | 360 | 8% | 7,314 | 302 | 7% | (242) | -40% | -5% | (58) | -16% | -1% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 5,555 | 401 | 8% | 4,346 | 202 | 5% | 5,903 | 234 | 5% | (198) | -49% | -4% | 32 | 16% | 1% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | 8,423 | 343 | 7% | 9,474 | 357 | 8% | 14,254 | 577 | 13% | 14 | 4% | 0% | 220 | 62% | 5% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 93 | 106 | 2% | 84 | 102 | 2% | 117 | 132 | 3% | (4) | -4% | 0% | 31 | 30% | 1% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | 288 | 66 | 1% | 256 | 60 | 1% | 227 | 54 | 1% | (5) | -8% | 0% | (6) | -10% | 0% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 4 | 32 | 1% | 4 | 27 | 1% | 5 | 23 | 1% | (5) | -17% | 0% | (4) | -15% | 0% |
| 1.9. Гянтболдын хүдэр, баяжмал | 1 | 17 | 0% | 2 | 13 | 0% | 1 | 10 | 0% | (4) | -22% | 0% | (4) | -26% | 0% |
| 1.10. Мөнгө /тонн/ | 42 | 33 | 1% | 54 | 10 | 0% | 89 | 37 | 1% | (22) | | 0% | 27 | 260% | 1% |
| 1.11. Бусад | 18 | 3 | 0% | 52 | 2 | 0% | 98 | 27 | 1% | (1) | -42% | 0% | 25 | | 1% |
| **2. Мал аж, ахуй** | | **342** | **7%** | | **306** | **7%** | | **293** | **7%** | **(36)** | **-11%** | **-1%** | **(12)** | **-4%** | **0%** |
| 2.1. Амьд мал, малын мах | 2 | 6 | 0% | 4 | 11 | 0% | 7 | 16 | 0% | 5 | 83% | 0% | 4 | 40% | 0% |
| 2.2. Арьс, шир | 270 | 32 | 1% | 293 | 29 | 1% | 144 | 20 | 0% | (3) | -9% | 0% | (9) | -30% | 0% |
| 2.3. Малын өлөн гэдэс | 0 | 7 | 0% | 0 | 8 | 0% | 0 | 6 | 0% | 1 | 14% | 0% | (2) | -30% | 0% |
| 2.4. Ноолуур | 6 | 282 | 5% | 6 | 238 | 6% | 7 | 229 | 5% | (44) | -16% | -1% | (9) | -4% | 0% |
| 2.5. Ноос, бусад үс, хялгас | 8 | 14 | 0% | 12 | 18 | 0% | 15 | 21 | 0% | 4 | 31% | 0% | 2 | 13% | 0% |
| 2.6. Бусад | 0 | 0 | 0% | 0 | 1 | 0% | 0 | 2 | 0% | 0 | 132% | 0% | 1 | 188% | 0% |
| **3. Газар тариалан** | | **22** | **0%** | | **25** | **1%** | | **19** | **0%** | **3** | **14%** | **0%** | **(6)** | **-25%** | **0%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | | **176** | **3%** | | **197** | **5%** | | **298** | **7%** | **21** | **12%** | **0%** | **102** | **52%** | **2.4%** |
| 4.1. Хүнс | 1 | 5 | 0% | 3 | 18 | 0% | 7 | 34 | 1% | 13 | 276% | 0% | 16 | 91% | 0% |
| 4.2. Ноолууран эдлэл | 1 | 22 | 0% | 1 | 24 | 1% | 1 | 24 | 1% | 2 | 7% | 0% | 0 | 1% | 0% |
| 4.3. Бусад хувцас, гутал, эдлэл | 1 | 6 | 0% | 1 | 9 | 0% | 2 | 13 | 0% | 2 | 38% | 0% | 4 | 46% | 0% |
| 4.4. Уул уурхай | 17 | 47 | 1% | 34 | 74 | 2% | 28 | 79 | 2% | 26 | 56% | 1% | 5 | 7% | 0% |
| 4.5. Цахилгаан, электрон бараа | 0 | 4 | 0% | 0 | 3 | 0% | 0 | 5 | 0% | (1) | -22% | 0% | 1 | 48% | 0% |
| 4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги | 2 | 84 | 2% | 1 | 63 | 1% | 1 | 137 | 3% | (21) | -24% | 0% | 73 | 115% | 2% |
| 4.7. Бусад | 183 | 7 | 0% | 176 | 6 | 0% | 203 | 8 | 0% | (1) | -19% | 0% | 2 | 31% | 0% |
| **5. Бусад** | | **2** | **0%** | | **2** | **0%** | | **1** | **0%** | **0** | **0%** | **0%** | **(1)** | **-62%** | **0%** |
| **Нийт дүн** | | **5,190** | | | **4,243** | | | **4,277** | | **(947)** | **-18%** | | **33.8** | **0.8%** | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth

**Хүснэгт 4.** Экспортын өөрчлөлт, 2016 он

| Төрөл | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **1. Уул уурхай** | **742.9** | | **(790.9)** | | **(48.0)** | **-1%** |
| 1.1. Зэсийн хүдэр, баяжмал | 109.6 | -19% | (684.4) | 119% | (574.8) | -28% |
| 1.2. Чулуун нүүрс | 322.2 | 122% | (58.4) | -22% | 263.8 | 52% |
| 1.3. Боловсруулаагүй нефть | (3.0) | 5% | (55.0) | 95% | (58.0) | -16% |
| 1.4. Төмрийн хүдэр, баяжмал | 61.7 | 196% | (30.2) | -96% | 31.6 | 16% |
| 1.5. Мөнгөжөөгүй алт /кг/ | 193.4 | 88% | 26.7 | 12% | 220.1 | 62% |
| 1.6. Цайрын хүдэр, баяжмал | 37.5 | 122% | (6.8) | -22% | 30.6 | 30% |
| 1.7. Жонш, лейцит, нефелинт | (7.0) | 122% | 1.3 | -22% | (5.7) | -10% |
| 1.8. Молибдений хүдэр, баяжмал | 3.1 | -75% | (7.3) | 175% | (4.2) | -15% |
| 1.9. Гянтболдын хүдэр, баяжмал | (2.0) | 56% | (1.5) | 44% | (3.5) | -26% |
| 1.10. Мөнгө /тонн/ | 14.8 | 55% | 12.2 | 45% | 27.0 | 260% |
| 1.11. Бусад | 12.4 | 50% | 12.6 | 50% | 25.0 | 0% |
| **2. Мал аж, ахуй** | **8.0** | **-64%** | **(20.4)** | **164%** | **(12.4)** | **-4%** |
| 2.2. Арьс, шир | (20.8) | 240% | 12.2 | -140% | (8.7) | -30% |
| 2.4. Ноолуур | 14.9 | -162% | (24.1) | 262% | (9.2) | -4% |
| **3. Газар тариалан** | **(0.0)** | **0%** | **(6.3)** | **100%** | **(6.3)** | **-25%** |
| **4. Аж үйлдвэрлэл** | **5.0** | **5%** | **96.9** | **95%** | **101.9** | **52%** |
| **5. Бусад** | **(0.3)** | **26%** | **(1.0)** | **74%** | **(1.3)** | **-62%** |
| **Нийт дүн** | **755.5** | | **(721.7)** | | **33.8** | **1%** |

** Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

2016 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 755.5 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 721.7 сая ам.доллараар буурсан байна. Мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ буурснаас голлон шалтгаалж 12.4 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 52%-иар буюу 101.9 сая ам.доллараар өсчээ.

**Зураг 4.** Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ




Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2016 оны 11 дүгээр сард 1,234 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.7%-иар өссөн бол өнгөрсөн сараас 2.5%-иар буурчээ. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 5,451, 73 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 14%-иар, төмрийн хүдэр 56%-иар өссөн бол өнгөрсөн сартай харьцуулахад харгалзан 15%, 24%-иар өсөөд байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 11 дүгээр сард 48 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс **52.3%**-иар, өмнөх сараас **18.5%**-иар тус тус өссөн.

Импорт 2016 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 11.9%-иар буюу 415.1 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 3 нэгж хувиар буурчээ.

**Хүснэгт 5.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

| Төрөл | 2014 | | | 2015 | | | 2016 | | | Δ (2015/2014) | | | Δ (2016/2015) | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Тоо/хэм (мян нэгж) | Дүн | % | Дүн | Өсөлт | %² | Дүн | Өсөлт | %² |
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | | **1,252** | **26%** | | **1,002** | **29%** | | **1,064** | **35%** | **(250)** | **-20%** | **-5%** | **62** | **6%** | **2%** |
| Түргэн эдэлгээтэй | 795 | 686 | 14% | 773 | 583 | 17% | 762 | 590 | 19% | (102) | -15% | -2% | 7 | 1% | 0% |
| *Хүнс* | *367* | 480 | *10%* | *341* | 403 | *12%* | *359* | 409 | *13%* | *(77)* | *-16%* | *-2%* | *6* | *1%* | *0%* |
| *Эм, тариа* | *3* | 70 | *1%* | *2* | 67 | *2%* | *2* | 83 | *3%* | *(3)* | *-4%* | *0%* | *16* | *24%* | *0%* |
| *Бусад түргэн эдэлгээтэй бараа* | *426* | 136 | *3%* | *430* | 114 | *3%* | *401* | 99 | *3%* | *(22)* | *-17%* | *0%* | *(14)* | *-13%* | *0%* |
| Удаан эдэлгээтэй | 157 | 567 | 12% | *161* | 419 | 12% | *120* | 474 | 15% | (148) | -26% | -3% | 55 | 13% | 2% |
| *Гутал, хувцас, цүнх* | *34* | 53 | *1%* | *43* | 46 | *1%* | *42* | 49 | *2%* | *(8)* | *-14%* | *0%* | *3* | *7%* | *0%* |
| *Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга* | *57* | 122 | *3%* | *66* | 83 | *2%* | *23* | 88 | *3%* | *(39)* | *-32%* | *-1%* | *4* | *5%* | *0%* |
| *Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл* | *2* | 323 | *7%* | *1* | 232 | *7%* | *1* | 280 | *9%* | *(91)* | *-28%* | *-2%* | *48* | *21%* | *1%* |
| *Бусад удаан эдэлгээтэй бараа* | *65* | 68 | *1%* | *51* | 58 | *2%* | *54* | 57 | *2%* | *(10)* | *-14%* | *0%* | *(1)* | *-2%* | *0%* |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | | **1,979** | **41%** | | **1,345** | **38%** | | **1,077** | **35%** | **(634)** | **-32%** | **-13%** | **(268)** | **-20%** | **-8%** |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд анги | 22 | 1,038 | 21% | 17 | 693 | 20% | 15 | 634 | 21% | (344) | -33% | -7% | (59) | -8% | -2% |
| *Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги* | 1 | 260 | *5%* | 1 | 106 | *3%* | 1 | 205 | *7%* | *(154)* | *-59%* | *-3%* | *99* | *94%* | *3%* |
| *Машин механик, тоног төхөөрөмж, эд анги* | 22 | 778 | *16%* | 16 | 587 | *17%* | 14 | 429 | *14%* | *(191)* | *-25%* | *-4%* | *(158)* | *-27%* | *-5%* |
| Барилгын материал | 2,638 | 731 | 15% | 1,608 | 451 | 13% | 667 | 268 | 9% | (280) | -38% | -6% | (183) | -41% | -5% |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа | 103 | 210 | 4% | 74 | 200 | 6% | 50 | 174 | 6% | (10) | -5% | 0% | (27) | -13% | -1% |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | | **536** | **11%** | | **468** | **13%** | | **466** | **15%** | **(68)** | **-13%** | **-1%** | **(2)** | **0%** | **0%** |
| Хүнсний орц | 58 | 31 | 1% | 40 | 25 | 1% | 187 | 52 | 2% | (6) | -19% | 0% | 26 | 104% | 1% |
| Химийн бүтээгдэхүүн | 111 | 84 | 2% | 114 | 81 | 2% | 114 | 78 | 3% | (3) | -4% | 0% | (3) | -4% | 0% |
| Даавуу, утас, арьс, савхин эдлэл | 28 | 15 | 0% | 17 | 14 | 0% | 25 | 17 | 1% | (1) | -4% | 0% | 3 | 21% | 0% |
| Цахилгаан эрчим хүч | 1 | 106 | 2% | 1 | 117 | 3% | 1 | 111 | 4% | 11 | 10% | 0% | (6) | -5% | 0% |
| Металлын хүдэр, баяжмал болон хаягдал | 1 | 0 | 0% | 0 | 1 | 0% | 1 | 1 | 0% | 1 | 214% | 0% | (0) | -6% | 0% |
| Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтат | 804 | 300 | 6% | 708 | 229 | 7% | 692 | 208 | 7% | (71) | -24% | -1% | (21) | -9% | -1% |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **1,026** | **1,052** | **22%** | **1,042** | **650** | **19%** | **939** | **467** | **15%** | **(401)** | **-38%** | **-8%** | **(183)** | **-28%** | **-5%** |
| Дизель түлш | 607 | 592 | 12% | 599 | 348 | 10% | 486 | 222 | 7% | (244) | -41% | -5% | (126) | -36% | -4% |
| АИ-92, АИ-95 | 278 | 294 | 6% | 325 | 209 | 6% | 296 | 147 | 5% | (86) | -29% | -2% | (62) | -30% | -2% |
| А-80 болон бусад | 140 | 166 | 3% | 118 | 94 | 3% | 157 | 99 | 3% | (72) | -43% | -1% | 5 | 5% | 0% |
| **Бусад** | **10** | **13** | **0%** | **19** | **29** | **1%** | **110** | **5** | **0%** | **16** | | **0%** | **(24)** | | **-1%** |
| **Нийт дүн** | | 4,832 | | | 3,495 | | | 3,080 | | (1,338) | -27.7% | | (415.1) | -11.9% | |

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 6.** Импортын өөрчлөлт, 2016 он

| Төрөл* | Тоо хэмжээний өөрчлөлт | % | Үнийн өөрчлөлт | % | Нийт өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|---|---|
| **Хэрэглээний бүтээгдэхүүн** | **32.3** | 52% | **29.6** | 48% | **61.9** | **6%** |
| Түргэн эдэлгээтэй | 8.8 | 120% | (1.5) | -20% | 7.3 | 1% |
| Удаан эдэлгээтэй | 23.5 | 43% | 31.1 | 57% | 54.6 | 13% |
| **Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн** | **(291.1)** | **108%** | **22.8** | **-8%** | **(268.4)** | **-20%** |
| Машин, механик тоног төхөөрөмж, эд анг | (101.3) | 172% | 42.5 | -72% | (58.8) | -8% |
| Барилгын материал | (183.8) | 101% | 1.0 | -1% | (182.8) | -41% |
| Хөрөнгө оруулалтын бусад бараа | (6.0) | 23% | (20.8) | 77% | (26.8) | -13% |
| **Аж үйлдвэрлэлийн орц** | **42.9** | | **(44.5)** | | **(1.6)** | **0%** |
| **Нефтийн бүтээгдэхүүн** | **(41.3)** | **23%** | **(142.0)** | **77%** | **(183.3)** | **-28%** |
| Дизель түлш | (51.7) | 41% | (74.0) | 59% | (125.7) | -36% |
| АИ-92, АИ-95 | (13.9) | 22% | (48.2) | 78% | (62.1) | -30% |
| А-80 болон бусад | 24.4 | 531% | (19.8) | -431% | 4.6 | 5% |
| **Бусад** | **4.4** | **-19%** | **(28.1)** | **119%** | **(23.7)** | **0%** |
| **Нийт дүн** | **(252.8)** | **61%** | **(162.3)** | **39%** | **(415)** | **-12%** |

** Ижил зориулалттай болович харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.*

2016 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 253 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 162 сая ам.доллараар тус тус буурчээ.

Хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ, үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 61.9 сая ам.доллараар өсчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 20%-иар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импорт 28%-иар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн үргэлжлэн буурч байсан хэдий ч 2016 оны 11 дүгээр сарын байдлаар тонн тутамд 543.9 ам.долларт хүрч 2 сар дараалан өсөөд байна.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/

